



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№21 /235/

2022.01.27

Цаг үе, үйл явдал

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ДАРГАЛАХ АЛБАН ТУШААЛЫН АХЛАГЧ НАРЫН ЦУГЛАРАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар даргалах албан тушаалын ахлагч нарын цугларалтыг энэ сарын 24-27-ны өдрүүдэд "Ахлагчийн албаны хөгжил, хэтийн төлөв" сэдвийн хүрээнд зохион байгуулж байна.

Цугларалтад Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, ЗХЖШ-ын орлогч дарга, ЗХЖШ-ын ахлагч, холбогдох албан тушаалтнууд өөрсдийн бэлтгэсэн сэдвийн хүрээнд "Зэвсэгт хүчний хөгжил ба ахлагчийн

алба", "Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний сургалтын өнөөгийн байдал, цаашид баримтлах бодлого, чиглэл", "Ахлагчийн албаны өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага", "Инновацийн хөгжил, ахлагчийн алба", "Зэвсэгт хүчний цэргийн сургалт

бэлтгэлийн талаар баримтлах бодлого, зохион байгуулж явуулах онцлог" сэдвүүдээр тус тус илтгэл тавин оролцож байна.

Зэвсэгт хүчний даргалах албан тушаалын ахлагч нарын цугларалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа бөгөөд I үе шатанд цугларалтад оролцогчдыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг шалгасан бол II үе шатанд онол, арга зүйн сургалт, хэлэлцүүлэг явагдаж байгаа юм.

Цугларалтад БХЯ, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын 50 гаруй цэргийн алба хаагч оролцож байна.

Цугларалтаар ахлагчийн албаны талаар цаашид баримтлах бодлого, нийгмийн хамгаалал болоод "Ахлагчийн албыг 2021 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн талаар илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлж байгаагаараа онцлогтой юм.

Ахлах ахлагч М.БАЯРСҮХ

Түүхэнд энэ өдөр

2006 он.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДААР М.СОНОМПИЛ ТОМИЛОГДОВ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-12	-31

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,851.00	2,853.0
EUR	3,205.0	3,220.0
CNY	450.00	451.00
RUB	36.00	37.80
JPY	24.70	24.95
KRW	2.36	2.39

ЗУРХАЙ



2022.01.27 ПҮРЭВ ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 25/

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:  
Нүд бүрэлзэн улцайна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.26-17.44  
Барилдлага:  
Үл тохирох  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Нэр өнгө  
Суудал: Гал

Энэ өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, лус тахиx, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу.

Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойшоо мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДОРНЫН ЗУРХАЙ:  
Хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд ЭЕРЭГ сайн

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2022 ОНЫ ЦЭРЭГЖЛИЙН ГИМНАСТИКИЙН АВАРГУУД ТОДОРЛОО



Жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 129 жилийн ойг угтан ҮБХИС-ийн нэрэмжит Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Цэрэгжлийн гимнастикийн тэмцээн энэ сарын 25-26-ны өдрүүдэд амжилттай явагдлаа. Тэмцээнд Зэвсэгт хүчний 30 орчим нэгтгэл, ангийн 280 гаруй цэргийн алба хаагч сонс эргэлт, модон моринд малгай тавьж харайх, олон төрөлт болон чөлөөт хөдөлгөөн гэсэн төрлүүдээр хурд хүч, авьяас чадвараараа өрсөлдөж, аваргуудаа тодрууллаа.

Үүнд: Чөлөөт хөдөлгөөний эрэгтэй төрлөөр I байрт дэслэгч Н.Батдорж (186), II байрт дэд ахлагч Э.Мөнх-Од

(330), III байрт ахлагч Г.Ууганбаяр (330). Чөлөөт хөдөлгөөний эмэгтэй төрлөөр I байрт сонсогч Т.Ану (029), II байрт сонсогч, олон улсын хэмжээний мастер Э.Элбэрэл (029), III байрт дэд ахлагч Г.Бодьжаргал (350) нар шалгарлаа.

Тэгвэл дүүжин төрөлд I байрт дэд ахлагч Э.Мөнх-Од (330), II байрт дэслэгч Н.Батдорж (186), III байрт цэргийн спортын дэд мастер, ахмад Б.Шинэ-Од (337) нар тус тус тэргүүлэв. Харин суга савлуурын төрөлд I байрт дэд ахлагч Э.Мөнх-Од (330), II байрт дэслэгч Н.Батдорж (186),

/Үргэлжлэл нь арын нүүрт/

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,269,389 /69.8%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,170,005 /66.7%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,002,623 31,0%
--	---	--

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 7844 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 199	ЭДГЭРСЭН 7529
------------------------------	----------------------------	------------------

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 363,219,652

Эдгэрсэн

Нийт: 287,658,286

Нас барсан

Нийт: 5,645,727

# ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2022 ОНЫ ЦЭРЭГЖЛИЙН ГИМНАСТИКИЙН АВАРГУУД ТОДОРЛОО



Түрүүч нь эхний нүүрт/ III байрт дэд ахлагч Б.Гансүх (084) нар шалгарлаа.

Модон морины төрөлд I байрт ахлагч Г.Ууганбаяр (330), II байрт ахлагч Д.Бүрэнтогтох (350), III байрт ахлагч З.Ариунболд (150) нар, олон төрөлтийн нийлбэр дүнгээр (эрэгтэй) I байрт дэд ахлагч Э.Мөнх-Од (330), II байрт дэслэгч

Н.Батдорж (186), III байрт ахлагч Г.Ууганбаяр (330) нар шалгарав.

Сонс эргэлтээр I байрыг ахлагч Т.Гантогтох (350), II байрыг ахлагч С.Батцэнгэл (327), III байрыг ахлагч Б.Балжинням (350) нар тэргүүлсэн бол модон моринд малгай тавьж харайх төрлөөр I байрыг ахлагч Л.Биндэръяа 13 малгайгаар (032), II байрыг дэслэгч М.Билгүүн 12 малгайгаар

(084), III байрыг ахлагч Ч.Ганзориг 12 малгайгаар (150) тэргүүлэв.

Ийнхүү эрэгтэй тамирчдын багийн дүнгээр тэргүүн байрт хурандаа Ж.Сүх-Очир захирагчтай Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн дэслэгч Н.Баасанцэрэнгээр ахлуулсан баг, дэд байрт дэд хурандаа Б.Олзбаяр захирагчтай Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ахлах

дэслэгч Э.Мөнх-Эрдэнээр ахлуулсан баг, гутгаар байрт хурандаа Н.Бат-Эрдэнэ захирагчтай Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн ахлах дэслэгч Х.Гантулгаар ахлуулсан баг тамирчид манлайллаа.

Эмэгтэйчүүдийн багийн дүнгээр тэргүүн байрт бригадын генерал П.Жаргалан захиралтай ҮХБИС-ийн Ч.Дашпүрэвээр

ахлуулсан баг, дэд байрт хурандаа Д.Жигжидсүрэн захирагчтай Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн ахлах ахлагч Э.Бархүүгээр ахлуулсан баг, гутгаар байрт хурандаа Ш.Цэрэнбат захирагчтай Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн дэд ахлагч П.Тэмүүжинээр ахлуулсан баг тамирчид шалгарлаа.

Тэмцээнийг цар

тахлын нөхцөл байдалтай уялдуулан халдвар хамгааллын дэглэмийг баримтлан явуулсан бөгөөд баг тамирчдаа бэлтгэн оролцуулсан Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн удирдлагад ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн Биеийн тамир спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ

## САР ШИНИЙН БАЯРЫГ УГТАН ЗАРИМ АХМАДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



ЗХЖШ-ын удирдлага, даргын зөвлөлийн гишүүд болон Ахмадын хорооноос сар шинийн баярыг угтан ахмадууддаа мэндчилгээ дэвшүүлэн хүндэтгэл үзүүлж байна. Тухайлбал, чөлөөнд байгаа хурандаа Л.Дашравдан, дэд хурандаа Г.Хаяабор нарын гэрт нь очиж хүндэтгэл үзүүлсэн

юм. АУГ-ын нэгдсэн ажиллагааны төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн хурандаа Д.Эрдэнэбилэг мэндчилгээг уламжлан "Та болон таны гэр бүлд ирж буй Бар жилдээ эрүүл энх, төвшин амгалан байхыг хүсэн ерөөе" гэлээ. Чөлөөнд байгаа хурандаа Л.Дашравдан "Миний сэтгэгдэл тун

өндөр байна. Ажил албаа их санаснаа сая л мэдэрлээ. Өнөөдөр цэргийн хүүхдүүд гэрт минь ороод ирсэнд их баяртай байна. Зэвсэгт хүчний удирдлага болон нийт бие бүрэлдэхүүнд аз жаргал, эрүүл энхийг хүсье. Та бүгдийн юу санасан есөн цагаан хүсэл сэтгэлчлэн бүтэх болтугай" хэмээв. Чөлөөнд байгаа хурандаа Л.Дашравдан хуучнаар Барилгын цэргийн 012 дугаар ангид инженер, барилгын ахлах инженер, хөдөлмөр хамгаалал, шинжлэх ухааны үндэслэлтэй хөдөлмөр зохион байгуулалт, ШБОС эрхэлсэн ахлах инженерээр долоон жил ажиллаад Ар талыг удирдах газрын Барилга-орон сууцны хэлтэст томилогджээ. Тэрээр тус хэлтсийн даргаар томилогдон ажиллаж байгаад 1997 гавьяаныхаа амралтад гарсан аж. Түүнээс хойш ч мөн барилга угсралт засварын "Таван-Өлзий" ХХК-г үүсгэн байгуулж, ерөнхий инженерээр нь 15 жил ажиллахдаа нийслэл, аймаг, сумдад бүтээн байгуулалт, засвар үйлчилгээ, тохижилт, өргөтгөл шинэчлэл зэрэг олон ажилд ханцуй шамлан орж, сурсан мэдсэнээ залуу үедээ зааж сургажээ.

Дараа нь чөлөөнд байгаа дэд хурандаа Г.Хаяаборт хүндэтгэл үзүүлээ. Тэрээр мөн сэтгэгдэл өндөр байгаагаар илэрхийлж, Зэвсэгт хүчний удирдлага, нийт бие бүрэлдэхүүнд ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсээд "Цэргийнхнийгээ харахаар их сайхан,



сэтгэлд дотно шүү. Цар тахлаас болоод мөрдэс нэгтгүүд маань цөөн үзэгдэх болж дээ" гэв. Тэрээр Ар талыг удирдах газрын Барилга-орон сууцны хэлтсийн санхүүгийн тасгийн даргаар ажиллаж байгаад 1989 онд гавьяаныхаа амралтад гарсан байна. Мөн БХЯ, ЗХЖШ, Ар талыг удирдах газраас бэлтгэлд гарсан бусад ахмадын

хамтаар "Насны баялаг" хоршоог байгуулж, үйлдвэрүүдийн хог хаягдлыг дахин боловсруулж, хүнсний савлагааны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнээс хойш өөрөө хүнсний ногоо тариалах зэргээр гар хумхилгүй хөдөлмөрлөснөө дурссан юм.